

АЛАГ ӨВС - ҮЕТЭНТ НУГЫН БҮЛГЭМДЛИЙН УРГАМЛЫН ЭКОЛОГИЙН БҮЛГИЙН БОЛОН АМЬДРАЛЫН ХЭЛБЭРИЙН ХАРЬЦАА ӨӨРЧЛӨГДӨХ НЬ.

Н. Нарантуяа доктор (Ph.D)

ШУА, Ботаникийн хүрээлэн, narantuya@botany.mas.ac.mn

Хураангуй.

Ургамалжлын талхлагдал, доройтол гэдэг ойлголтонд зөвхөн түүний зүйлийн бүрдэл багасах, ургацын хэмжээ буурах биш, харин тухайн ургамал бүлгэмдлийг бүрдүүлэгч ургамлуудын биологи, морфологи, экологийн онцлог, мөн ургамлын ургах орчин болох хөрсний, ялангуяа чийгийн өөрчлөлтүүдийг судлах асуудал хамаарна.

Иймд бид энэ өгүүлэлд алаг өвс-үетэнт нугын бүлгэмдэлд үзүүлэх ашиглалтын горимын (мал бэлчээрлэлт) нөлөөг тухайн бүлгэмдлийг бүрдүүлэгч ургамлуудын экологийн болон амьдралын хэлбэрийн харьцаа, хөрсний чийгийн өөрчлөлтүүдийг судалсан судалгааны дүнг тусгасан болно.

Зангилаа үг: экологийн бүлэг, бэлчээрлэлт, хөрсний чийг, талхлагдал.

ОРШИЛ.

Сүүлийн жилүүдэд эрчимжиж буй цаг агаарын өөрчлөлт, тухайлбал агаарын температурын өсөлт, дулаарал, хүний хүчин зүйлсийн зохисгүй харьцаа зэрэг сөрөг нөлөөллүүд монгол орны бэлчээр, ургамалжил талхлагдахад хүргээд байгаа билээ. Бэлчээрийн талхлагдал нь зөвхөн ургамлын зүйлийн ядуурал, ургацын бууралт биш тэдгээрт зонхилох ургамлуудын экологийн бүлэг, амьдралын хэлбэрийн харьцаа, ургамлын насны спектр, биоморфологийн болон ургамлын ургах орчин хөрсний өөрчлөлт зэргээр илэрдэг, өөрөө хэлбэл ургамалжлын талхлагдал, түүний зэргийг зөвхөн ургамалжлын ерөнхий төлөв байдлаар бус зонхилох ургамлынх нь өөрчлөлтүүдээр илэрхийлдэг байна.

Судалгааны ажлын зорилго нь нугын ургамал бүлгэмдлийн талхлагдлыг зонхилох ургамлынх нь экологийн бүлэг, амьдралын хэлбэрийн харьцааны өөрчлөлт болон хөрсний чийгийн өөрчлөлтөөр илэрхийлэхэд оршино.

Судалгааны объект, аргазүй. Манай орны ойт хээрийн бүслүүрт нилээд өргөн тархдаг зонхилох ургамал бүлгэмдэл болох алаг өвс-үетэнт бүлгэмдлийн сонгосон болно. Нугын ургамал нөмрөгт мал бэлчээрлэлтийн үзүүлэх нөлөөг судлахдаа геоботаникийн харьцуулсан сорил судалгааны арга, МЗХБИБЭ-ийн боловсруулсан ерөнхий аргазүйн дагуу О. Чогнийн (1975) бэлчээрийн өөрчлөлт, сэргэлтийг судалсан аргазүйг үндэслэн судалгаа явуулав. Ургамал бүлгэмдлийн зүйлийн бүрдлийг судлан тогтоосны дүнд тэдгээрийг экологийн бүлэг, амьдралын хэлбэрээр ангилан, бүлэг тус бүрээр тухайн ургамлын бүрхэц (%), ургац ($г/м^2$) зэргийг тодорхойлон гаргав.

Хөрсний чийгийн дээжийг хөрсний үе тус бүрээс 3 давталттай авч, термостат-д 105^0 С-д 8 цаг хатааж, үнэмлэхүй хуурай жинг тодорхойлж байв.

Судалгааны үр дүн:

Мал бэлчээрлэлтийн нөлөө ихсэх тусам ургамал нөмрөг, орчин зүйн нөхцөл нь хуурайсаж, улмаар чийгсэг бүлгийн ургамал багасаж, хуурайсаг бүлгийн ургамал ихэсдэг

тухай олон эрдэмтэд, судлаачид (Куделин, 1951, Герцык, 1955, Касач, 1969, Лошаков, 1978) нотолсон байдаг.

В.В. Герцык (1950) Оросын хар шороон төвийн бүсийн улсын дархан цаазат газрын хөрсний чийгшил бүтцэд болон ургамал нөмрөгт мал бэлчээрлэлтийн нөлөөг судлаж, мал бэлчээрлэлт ихсэх тусам хөрсний өнгөн давхрага хуурайшиж, нягтардаг, харин хөрсний 100 см хүртэлх давхаргад ургамлын үндэсний хэмжээ багасдагаас шалтгаалан чийг хангалттай хадгалагддаг гэсэн дүгнэлтийг гаргасан байдаг. Мөн В. Л. Куделин (1951) бэлчээрлэлтийн нөлөөгөөр нугын бүлгэмдлийн хөрсний өнгөн үе хуурайшин нягтардаг тухай тэмдэглэсэн байдаг.

Иванова (1967) Лена мөрний хөндийн Нашскийн районд хөрс, ургамалжилд мал бэлчээрлэлтийн нөлөөг судалсанахаа дүнд ялангуяа хур тунадас багатай, хуурайдуу жил мал бэлчээрлэлтийн нөлөөгөөр хөрс хуурайшин, давс ихэсдэг болохыг илрүүлжээ.

Бидний судалгаанаас үзэхэд нугын бүлгэмдэлд мал бэлчээрлэлтийн нөлөө хэдий чинээ их болох тусам бүлгэмдлийн хөрсний өнгөн үеийн чийг төдий чинээ багасдаг нь ажиглагдав (Хүснэгт 1).

1-р хүснэгт Үетэн- алаг өвст нугын бүлгэмдлийн хөрсний чийгийн (%) өөрчлөлт. (1989)

Хөрсний гүн см	Бүлгэмдлийн өөрчлөлтийн үе		
	Бага	дунд	их
0-10	5,7	4,6	4,0
10-20	6,0	4,9	5,0
20-30	6,0	6,8	5,1
30-40	6,3	7,0	6,9
40-50	8,3	10,9	11,2

Хүснэгтээс харахад судалгаанд хамрагдсан үетэн-алаг өвст нугын бүлгэмдлийн мал бэлчээрлэлтийн нөлөөгөөр их өөрчлөгдсөн үеийн хөрсний 0-20 см гүний чийгийг бага үеийнхтэй харьцуулахад 1,0-1,7% багасаж, харин 40-50 см гүний хөрсний чийг 2,9 %-иар ихсэж буй зүй тогтол ажиглагдав. Энэ нь нугын бүлгэмдлийн хөрс 50 см-ээс дооших гүнд цэвдэгтэй, чийг хангалттай байдагтай холбоотой байна.

Илэрхийлэл: Үетэн-алаг өвст нугын бүлгэмдлийн хөрсний чийг 0-20 см гүний чийгийг бага үеийнхтэй харьцуулахад 1,0-1,7% багасаж, харин 40-50 см гүний хөрсний чийг 2,9 %-иар ихсэж буй зүй тогтол ажиглагдав. Энэ нь нугын бүлгэмдлийн хөрс 50 см-ээс дооших гүнд цэвдэгтэй, чийг хангалттай байдагтай холбоотой байна.

Илэрхийлэл: Үетэн-алаг өвст нугын бүлгэмдлийн хөрсний чийг 0-20 см гүний чийгийг бага үеийнхтэй харьцуулахад 1,0-1,7% багасаж, харин 40-50 см гүний хөрсний чийг 2,9 %-иар ихсэж буй зүй тогтол ажиглагдав. Энэ нь нугын бүлгэмдлийн хөрс 50 см-ээс дооших гүнд цэвдэгтэй, чийг хангалттай байдагтай холбоотой байна.

Илэрхийлэл: Үетэн-алаг өвст нугын бүлгэмдлийн хөрсний чийг 0-20 см гүний чийгийг бага үеийнхтэй харьцуулахад 1,0-1,7% багасаж, харин 40-50 см гүний хөрсний чийг 2,9 %-иар ихсэж буй зүй тогтол ажиглагдав. Энэ нь нугын бүлгэмдлийн хөрс 50 см-ээс дооших гүнд цэвдэгтэй, чийг хангалттай байдагтай холбоотой байна.

урожай многолетних трав. –Канд. дисс. с-х. наук. Рига, 1951. –с 31-38.

Лошакова А.Н. Пастбищная дигрессия кормовых угодий при Ангарья. –Дисс. Оан. Биол. Наук. Иркутск, 1978. -120 с.

Ю. М. Динамика степной и пустынной растительности центральной части МНР. –Канд. дисс.биол.наук. Л., 1967. -132 с.

М.А. Степи Западного Забайкалья. –Труды Вост. Сиб. Филиала. 1961, сер. биол, вып. 34, -173 с.

Э. А. Экологическая морфология растений. М., Высшая школа. 1962.-438 с.

О. Дорнод хангайн бэлчээрийн өөрчлөгдөх, сэргэх зүй тогтол. // БНМАУ-ын ургамлын аймаг, ургамалжилтын судалгаа. Дэд боть. УБ., 1981. –х. 179-279.

А. А. Кормовые растения и сенокосов МНР. М-Л., 1954. –с. 123-146.

Summary.

The change of plant ecological and life form groups in the forb-grass meadow plant community.

N. Narantuya

Institute of Botany. MAS.

With increasing grazing in meadow plant community due to compaction of soil surface layer, infiltration is deteriorated. It leads to the plant grow environment xerophytisation and steppization (as transformation into steppe) of meadow plant community.

As result of this, in degraded by grazing plant community increased xerophytes and rhizome plants, decreased mesophytes and tap root plants.

